

XX ЗУУНЫ МОНГОЛ, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ТУРШЛАГА

Ч.Баянжаргал

Товч агуулга: Тус өгүүлэлд, үйл явцын өөрчлөлтөд шийдвэрлэх хэмжээгээр нөлөөлсөн хүчин зүйлсийн далайц, хүрсэн үр дүн, цаашдын хандлагыг иш үндэс болгож, ойролцоо цаг хугацааг авч үзэж буй асуудлын эхлэл, төгсгөлд хамааруулан хэлэлцдэг зарчмыг баримтлан, XX зууны Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны түүхэн туршлагыг авч үзэв.

Түлхүүр үг: XX зуун, Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа, түүхэн туршлага

Удиртгал

Арга зүй. Нийгмийн хөгжил, хөдөлгөөний аливаа асуудлыг сар, өдрөөр байтугай жилээр нарийвчлан хэмжиж тодорхойлж болдоггүй. Учир нь, тийм механик хэрчлээс өөрөө нийгэм судлалд зохисгүй. Иймээс үйл явцын өөрчлөлтөд шийдвэрлэх хэмжээгээр нөлөөлсөн хүчин зүйлсийн далайц, хүрсэн үр дүн, цаашдын хандлагыг иш үндэс болгож, ойролцоо цаг хугацааг авч үзэж буй асуудлын эхлэл, төгсгөлд хамааруулан хэлэлцдэг зарчмыг баримтлав.

Арга зүйн ийм зарчмыг удирдлага болговол Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагааны түүхийг XX зуун эхлэх торгон мөчтэй зэрэгцүүлэн үзэх аргагүй юм. Нөгөө талаар XX зууны Монгол, Оросын эдийн засгийн харилцааны үндсийг бүр урагшлуулж XIX зуунд, тухайлбал, Монгол руу чиглэсэн өрнөдийн капиталын өрсөлдөөний явц, мөн зууны шувтарга үеийн нөхцөл байдалтай уялдуулан мөшгин үзэж болох нэг сэжиг байгаа ч гэлээ тэнд, бидэнд хэрэгтэй зүйл үнэндээ үгүй байна. Тэгээд ч тэр үед Монгол улс хоёр талын хөршийн улс төрийн бодлогын ажиглах талбар болж байв. Тиймээс, Монгол улс эдийн засгаа өөд татах хэрэгт гаднаас, ялангуяа хаант Оросоос дэмжлэг олно гэж найдаж байсан нь талаар болсон юм¹. Нөгөө талаар, Монгол, Орос хоёр хоёулаа өөр хоорондоо цөөн жилийн зайтайгаар (1917,

¹ Монгол улсын түүх Ү боть (XX зуун) УБ.2003., тал 94.

1921) XX зууны 20-иод оны орчим л нийгмийн адил шинж бүхий тогтолцооны босгыг алхаж орсон билээ.

Энэ бодит байдлын улмаас, энд авч үзэж буй асуудал буюу XX зууны Монгол, Оросын эдийн засгийн харилцааны түүхийг 20-иод оноос “эхлүүлэх” нь зүйд нийцэх юм. Түүгээр ч үл барам энэ түүхийн (ер нь нийт хамтын ажиллагаа) бас нэг онцлог нь цаг хугацааны хувьд XX зууны төгсгөлийн торгон мөчтэй ч давхцахгүйгээр өөр хэв шинжид шилжсэн явдал болно.

Товчхон тодруулбал, XX зууны Монгол болон шинэ Оросоос өмнөх үеийн эдийн засгийн хамтын ажиллагаа нь 70 жилийн түүх ба туршлага юм.

1.Түүх эхэлсэн түүх

Өнгөрсөн зууны “Шинэ” Монголын түүх 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалаас эхтэй. Энэ нь Их Оросын ард түмэн, тухайн үеийн хамгийн дэлгэрмэл, хүндэтгэлтэй хандлагын хэллэгээр бол Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын тал бүрийн дэмжлэг тусламжтай чухамхүү амин холбоотойгоор үргэлжилсэн үйл явц билээ.

Түүхийн хуудсуудыг сөхвөл, 1920 оноос Монгол ба Зөвлөлт Оросын хоорондын худалдаанд гаалийн хөнгөлөлт тогтоохоор харилцан тохирч, 1923 онд Монгол улс, Зөвлөлт Орос улсын хооронд худалдаа, эдийн засгийн гэрээ байгуулагдсан. Уг гэрээ ёсоор, Зөвлөлт Орос Улс хувьсгалын өмнө Монголд ажиллаж байсан “Центрсоюз” гэдэг худалдааны салбарын зэрэгцээ “Сибгосторг”, “Дальгосторг”, “Конжсиндикат” зэрэг худалдааны байгууллагуудын салбаруудыг ажиллуулах болсон байна. Эдгээр нь зонхилж Монгол ардын харилцан туслах хоршоо (МАХТХ)-той хамтран ажиллаж, түүнийг өсөж хөгжихөд бүх талын дэмжлэг үзүүлж байв.

1924 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулав. Энэ банкныг байгуулах ажил урьдаас бэлтгэгдсэн бөгөөд ямар ач холбогдолтой болохыг нотолсон баримт нь МАН-ын II их хуралд илтгэсэн Засгийн газрын илтгэл юм. Тэнд: Банк хэмээх мөнгөний пүүсгүй болохоор цаасны үнэ тогтвортой болж үл чадах учир мөнгөний пүүсийг Орос лугаа хоршоолон байгуулахаар хэлэлцэж буй ба эдгээр зүйлд хөрөнгө болгохоор Орос улсаас таваад цэнгийн мөнгөн төгрөг нэгэн зуун түмийг хүүгүй зээлдэн авахаар тогтоогоод байгааг² тэмдэглэсэн байна. Энэ банкныг байгуулсан нь Монгол улсын санхүүгийн тогтолцоог шинээр бий болгож энэ чухал салбарыг эзэмшиж эдийн засгийн тусгаар тогтнолоо хангах нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

² Монгол Ардын Хувьсгалт намын хоёрдугаар их хурал. УБ. 1974. тал 32

2. Цаашдын замнал

Олон улсын түвшин дэх ээдрээтэй нөхцөл, хоёр орны улс төрийн ашиг сонирхол төдийлөн нийлэмжтэй бус байдлын улмаас Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа 20-иод оны II хагаст бага зэрэг саатсан билээ³. Гэвч 1929 оноос 6-р сарын 27-нд Улаанбаатар хотноо байгуулсан хоёр орны харилцааны үндсэн зарчмын тухай хэлэлцээр ёсоор тус орны мал аж ахуй болон эдийн засгийн шинэ салбарууд: орчин цагийн үндэсний тээврийг үүсгэн хөгжүүлэх, урьд байгуулсан Худалдаа, аж үйлдвэрийн банкны хөрөнгө хүчийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, гадаад худалдааны нөхцөлийг хөнгөвчлөх, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг улам өргөтгөв. 1929 оны 12-р сарын 30-нд хувь нийлүүлсэн "Монголтранс"-ыг 50 машин, жижиг засварын газартайгаар байгуулжээ. Тэр үед Монгол, Зөвлөлтийн эдийн засгийн хамтын ажиллагаанд хувь нийлүүлсэн үйлдвэр, аж ахуйн газрын хэлбэр зонхилж байв. Энэ нь хөрөнгө хүч ба боловсон хүчний талаар хэрэг дээрээ юу ч үгүй Монгол улсын хувьд хамгийн зохистой хэлбэр байв.

Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд ЗХУ-ын техник, эдийн засгийн болон мэргэжилтний тусламжтайгаар улсын томоохон үйлдвэрийн газруудыг барьж байгуулсан. Тухайлбал, Хатгалын ноос угаах үйлдвэр 1933 оны 7-р сард, Улаанбаатарын дулааны цахилгаан станц 1934 оны 2-р сард, манай орны аж үйлдвэрийн хамгийн том цогцолбор болох Аж үйлдвэрийн комбинат 1934 оны 3-р сард тус тус ашиглалтанд орсон байна.

1940 он гэхэд Монголын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 1934 оныхоос 6 дахин өсч, мөн оны байдлаар, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр 20%-ийг эзлэх болсон байв.

Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа дайны хүнд бэрх жилүүдэд ч онцлог байдалтайгаар тасралтгүй үргэлжилсэн юм. Энэ үед ЗХУ-ын тусламжтайгаар тус оронд ноос угаах болон суран эдлэлийн үйлдвэр, шүдэнзний үйлдвэр, альбастрын цех зэрэг газрууд ашиглалтанд орсон юм.

1941-1945 онд Чойбалсан Улзын засмал замыг байгуулж, Сэлэнгэ, Завхан, Ховд аймагт 65 гүүр барьж, Улаанбаатарын аж үйлдвэрийн комбинатын ноос угаах үйлдвэрийг өргөтгөж, Махкомбинатын барилгыг эхлүүлжээ.

Дайны үеийн хоёр орны хоорондын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны нэг онцлог бол Монголын ард түмэн өөрийн бүх нөөц бололцоог шавхан дайчилж, зөвлөлтийн нийт ард түмний шударга дайны ялалтад бүхнээ зориулж байсан явдал болно. Дайны жилүүдэд Монголын аж үйлдвэр Зөвлөлтийн байгууллагуудын захиалгыг биелүүлж, мал аж ахуйн болон

³ Энд, Коминтерний тулгалтаар, Монголд улс орны удирдлагад зүүн оппортунизм гарч ирснээс, шинэ эргэлтийн бодлого хүртэлх завсарын тухай өгүүлж буй

хүнсний бүтээгдэхүүн, төрөл бүрийн дулаан хувцас зэргийг нийлүүлж байв. Түүнчлэн Монголын ард түмний хуримтлуулсан хөрөнгөөр “Хувьсгалт Монгол” танкийн цуваа, “Монгол ард” нисэх онгоцны эскадрил байгуулж Зөвлөлтийн армид бэлэглэсэн бөгөөд дайн дуустал тэдгээрийн байлдагчдийн хоол, хувцасыг хангаж байв. Энэ зүтгэл чармайлт бол, дэлхийн империализмын сөрөг талд зогсож байсан хоёрхон орны хувьд ч, Монгол улс, ЗХУ-ын бүх талын дэмжлэг тусламжинд тулгуурлаж байсны хувьд ч хийх ёстой ажил, ядарсан цагт нөхрийн чанарыг харуулсан үйл хэрэг, түүхийн нэгэн үзлэгт шалгагдсан явдал мөн.

Дэлхийн II дайн Монголын эдийн засагт үлэмж хохирол учруулсан юм. 1941-1945 онд эдийн засагт зарим ахиц байсан боловч дайн тус орны үйлдвэрлэх хүчний хөгжлийг ихээр саатуулсан билээ. 1945 онд мал сүргийн тоо 20,5 сая болсон ба 1944-1945 оны зудын улмаас мал үлэмж хорогдсон. Ийм нөхцөлд Зөвлөлтийн тал Монголын мал эмнэлгийн боловсон хүчин бэлтгэх ажилд их анхаарал тавьсан байна. Түүний дүнд 1946 онд Монголд мал эмнэлгийн газар 572, тэдгээр дунд боловсрол бүхий 945 мэргэжилтэн ажиллах болсон байв³.

Дайны дараах жилүүдэд ЗХУ-аас импортолсон бүтээгдэхүүний хэмжээ өссөний дүнд Монгол улсын төсвийн орлого ч өсөв. Түүнчлэн зөвлөлтөөс нийлүүлсэн барааны жижиглэн худалдаалах үнийг бууруулах боломж бүрдсэн бөгөөд 1946 оны 11-р сард ногоон цай, тамхи, ётон, амуу будаа, нэхмэл бүтээгдэхүүний үнийг дунджаар 35,5% бууруулсан байна⁴. Зөвлөлтийн бүтээгдэхүүний борлуулалтын орлого, тухайлбал, гаалийн хураамж, гүйлгээний татвараас орох төсвийн нэмэгдэл 1942-1946 онд 32,1-54,7% болж өсчээ⁵.

1946 оны 2-р сарын 27-нд Монгол, Зөвлөлтийн хооронд найрамдал, харилцан туслах тухай шинэ гэрээ байгуулагдав. Энэ гэрээ дайны дараах үеийн хоёр талын хамтын ажиллагаанд маш чухал ач холбогдолтой болсон юм. ЗХУ-аас Монголын аж үйлдвэр, тээвэр, мал аж ахуй болон эдийн засгийн бусад салбарыг хөгжүүлэхэд үлэмж их анхаарал тавив. Хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа идэвхтэй үргэлжиллээ. 1946 оны их гангийн улмаас ЗХУ-ын хөдөө аж ахуйд үлэмж бэрхшээл учирч, хүн амын хүнсний хангамж хүндэрсэн тул ЗХУ-ын Засгийн газар Монголын Засгийн газарт хандаж, 1947 онд мах, өөхөн тос зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлтээ нэмэгдүүлэхийг хүссэн. Монголын тал уг хүсэлтийг хүлээн авч, амьдын жингээр 120 мян.тн мах, 3000 тн тос нийлүүлжээ. Мөн хугацаанд Зөвлөлт

³ История Монголии. XX век. М.2007. с.191

⁴ Мөн тэнд с.192

⁵ Мөн тэнд с.193

улсаас Монголд 2000 тн үр тариа нэмж олгосны дээр, хөвөн, цаасан болон торгон нэхмэлийн зүйл (3 сая м, 300 мянган м), ачааны машин (200 ш) болон бусад бараа нийлүүлсэн байна. 1948 оны байдлаар хоёр орны хоорондын бараа эргэлт 1945 оныхоос 29%, Зөвлөлтийн бүтээгдэхүүний нийлүүлэлт 43%, Монголынх 14% өсчээ.

Түүхэн энэ үе бол цаг хугацааны хувьд Монгол улсад анхдугаар таван жилийн төлөвлөгөө эхлээд байсан үе. 1949 оны 2-р сард хуралдсан БНМАУ-ын Ардын Их Хурал улс орны хөгжлийн хэтийн төлөвийг хэлэлцэж, 1948-1952 онд тус орны улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталсан юм. Тус орон анхдугаар 5 жилийн төлөвлөгөөт зорилтоо хэрэгжүүлэх явцад эдийн засгийн талаар Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагааны хүрээнд, юуны өмнө, уул уурхайн үйлдвэр, тухайлбал, Бүрэнцогт, Түмэнцогт, Чулуунхороот, Цэнхэрмандалын хүдрийг олборлох, баяжуулах ажил хийсэн байна⁶.

1940-өөд оны II хагаст авто болон төмөр замын тээврийн хөгжилд голлон анхаарсан юм. 1949 онд Улаанбаатар-Наушкийн төмөр замыг ашиглалтад оруулав. Түүнчлэн Монгол, Зөвлөлтийг холбосон Тамсаг булаг-Соловьевскийн засмал зам, Улаанбаатар-Сайншанд, Улаанбаатар-Алтанбулагийн төмөр замыг барьж байгуулжээ.

Зөвлөлтийн техник үндэслэсэн өвс хадах морин станцын тоо 5 жилийн хугацаанд 5 дахин өсөв.

Төлөвлөгөөт 5 жилд уул уурхайн үйлдвэрийг оролцуулан, хувь нийлүүлэх зарчимд үндэслэн байгуулсан аж үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүний гаргалт хоёр дахин өсчээ. Мөн хугацаанд хоёр орны хоорондын бараа эргэлтийн хэмжээ: импортын хувьд 26,4%, экспорт нь 15,6% өссөн байна⁷.

Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний биелэлтийг 1953 оны 3-р сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны бүгд хурал нэгтгэн дүгнэсэн байна. Тэнд өгүүлснээр: 1947 онтой харьцуулахад улс ардын аж ахуйн социалист сектор өргөжин тэлж, аж үйлдвэрийн шинэ шинэ салбарууд үүсэн байгуулагдаж, механикжсан тээвэр хөгжин, улс орны үйлдвэрлэхүй хүч бэхэжсэн нь Монгол, Зөвлөлтийн өргөн хамтын ажиллагааны бодит үр дүн юм.

3. Социализмыг зорьсон жилүүдэд

БНМАУ, 1950-иад оны эхээр дайны гамшиг хохирлыг арилгаад, 1953-1957 онд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх хоёрдугаар таван жилийн

⁶ Монгол Улсын түүх. Ү боть (XX зуун) УБ.2003. тал 264

⁷ История Монголии. XX век. М.2007. с.197

төлөвлөгөөнд шилжин оров. Энэ үеийн үндсэн зорилт нь эдийн засгийн социалист сектор өсгөж бүх талаар бэхжүүлэн хөгжүүлэх явдал байв.

1950-иад оны сүүлч гэхэд, Монгол улс, ЗХУ-ын тусламжтайгаар үндэсний аж үйлдвэр орчин цагийн тээврийн салбарууд харилцаа холбоог хөгжүүлж тодорхой амжилтанд хүрсэн боловч эдийн засгийн нэн сул хөгжилтэй орон хэвээр байв. Эдийн засгаа хөгжүүлэхийн тулд олон удаагийн таван жилийн төлөвлөгөө (1990 он хүртэл) баталж, мөрдөж байв. Мэдээжээр, эдгээр нь ЗХУ-ын зөвлөхүүд, мэргэжилтнүүдийн шууд оролцоо тусалцаатайгаар боловсруулагддаг байв. Тэр тусмаа эдгээр төлөвлөгөө дотоодын нөөц хүчинд тулгуурлахаас гадна, бүр эхнээсээ гадаадын тусламж дэмжлэг, юуны өмнө, ЗХУ-ын хөнгөлөлттэй зээл, тусламжинд найдаж төлөвлөгддөг байсан нь тодорхой билээ. Таван жилүүдийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл явцын бодит алхам бүр тийм байдалтай үргэлжилсээр байв. Ялангуяа 1960-аад оноос ЗХУ-ын хөнгөлөлттэй зээл, тусламж, бусад социалист орнуудын тусламжаар Монголд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, нийгэм-соёлын болон бусад салбарын хэдэн зуун объектуудыг барьж байгуулсан юм.

ЗХУ 1966-1970 онд БНМАУ-д 650 сая рублийн (буцалтгүй тусламжаас гадна) зээл олгов. ЗБСБНХУ-ын гадаад худалдааны банкны мэдээгээр, 1976 оны 9-р сарын 20-ны байдлаар ЗХУ-аас Монголд 3235,1 сая рубль олгосон байна. Монголын YI таван жилийн төлөвлөгөөг (1976-1980) хэрэгжүүлэхэд 1525 сая, YII таван жил (1981-1985)-ийн зорилтуудыг биелүүлэхэд 2,5 тэрбум рубль олгосон. Эдгээр нь тэр үедээ асар их хөрөнгө байв. 1961-1965 онд ЗХУ-аас олгосон зээл, Монголын хөрөнгө оруулалтын 47%-ийг эзэлж байсан бол 1966-1970 онд 50%, 1971-1975 онд 52% хүрч, 1980 онд 80% хүрсэн байна⁸.

Эдгээр зээлийн дийлэнхийг улс ардын аж ахуйн янз бүрийн барилга байгууламжид зориулсан бөгөөд энэ ажлыг гүйцэтгэхийн тулд Монголд Зөвлөлтийн барилгын 3 том трест байгуулсан. Эдгээр трест Дархан, Эрдэнэт гэсэн аж үйлдвэрийн том хотуудыг шинээр босгож, Улаанбаатарт олон арван үйлдвэрийн газар байгуулж “түлхүүр хүлээлгэж өгсөн” юм. Монголын эдийн засгийн хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон том үйлдвэрүүд болох: Уулын баяжуулах үйлдвэр “Эрдэнэт” 1981 онд бүрэн хүчин чадлаараа (жилд 16 сая тн) ашиглалтад орсон; Багануур, Шарын голын болон Адуун чулууны нүүрсний уурхай (нийт хүчин чадал нь 4,4 сая тн); Улаанбаатарын IY цахилгаан станц (хүчин чадал 380 МВТ); 420 мян.тн хайлуур жонш гаргах уурхай, Эрдэнэтийн хивсний комбинат (1.3 сая м² бүтээгдэхүүн үйлдвэрлэх) болон 2 сая м² талбай бүхий орон сууц барьсаны дээр, 50 сая га бэлчээр усжуулж, хөдөө аж ахуйн болон бусад 30 том объект⁹ байгуулжээ.

⁸ История Монголии. XX век. М.2007., с.238

⁹ Мөн тэнд с.239

1980 онд ЗХУ-ын тусламжтайгаар байгуулсан үйлдвэрийн газрууд Монголын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний бараг 50%, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 20%-ийг үйлдвэрлэж байв. Салбараар авч үзвэл, тэдгээр нь нүүрс олборлолтын 83%, хайлуур жоншны 86,4, тоосго үйлдвэрлэлийн 68, цементийн 96, гурил ба сүүн бүтээгдэхүүн, зэс, молибдений баяжмалыг 100% гүйцэтгэж байв¹⁰.

Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, түүний дотор газар тариалангийн салбарт хамтарсан үйлдвэрийн газар, нэгдлүүд амжилттай ажиллаж байв. Хувь нийлүүлсэн “Улаанбаатар” төмөр зам; өнгөт металл олборлох, баяжуулах, “Монголсовцветмет” аж ахуйн нэгдэл зэрэг нь Монголын эдийн засгийн чадавхийг өсгөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Өнгөрсөн зууны Монголын эдийн засгийн хөгжилд 20-иод оноос эхтэй хоёр орны гадаад худалдаа ихээхэн үүрэг гүйцэтгэсэн билээ. Өгүүлбэл: Улсын төсвийн орлогын 40 гаруй хувь нь ЗХУ-тай хийсэн гадаад худалдааны орлогоос бүрдэж байв. ЗХУ-тай хийдэг гадаад худалдаа 1969 онд Монголын нийт гадаад худалдааны эргэлтийн 80 илүү хувь байсал бол 1984 онд 87% болсон ажээ. Энэхүү гадаад худалдаанаас монголчуудын өргөн хэрэглээний барааны хангалт хамаарч байсан төдийгүй тэр нь улс орны аж үйлдвэр, барилгын үйлдвэрлэлийн чухал хүчин зүйл болж байсан юм.

ЗХУ-аас нийлүүлдэг бүтээгдэхүүнээр тус орны техникийн (моторын) түлшний нийт хэрэгцээ, олон төрлийн түүхий материал, аж үйлдвэр, хүнсний бүтээгдэхүүний зарим төрөл, түүнчлэн машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэгийн нөөцийн 80 хувь нь хангагдаж байв.

Тэгэхдээ хоёр орны хоорондын гадаад худалдаа Зөвлөлтийн талд илүү их ашигтай байсныг шударгаар тэмдэглэвэл зохих билээ. Юуны өмнө, Монголоос, хамгийн үнэт минералын түүхий эд болох зэс, молибдены баяжмал (концентрат), хайлуур жонш, алт, мөнгө, амьд мал, мах, мал аж ахуйн бусад бүтээгдэхүүн; хивс, арьс ширэн болон ноосон эдлэл үлэмж ихээр хямд экспортлогдож байсан юм.

1950-иад оноос ихээхэн идэвхтэй байдалд орсон Монгол, Зөвлөлтийн гадаад худалдааны өсөлтийн мэдээ тодорхой зүйлийг бидэнд харуулж байна.

Хүснэгтийн эхний ба төгсгөлийн хоёр таван жилийн байдлыг харьцуулан үзэхэд энэ хооронд хоёр орны гадаад худалдаа 10 дахин өссөн байна. Тэгэхдээ солилцооны эцсийн дүн Монголд ямагт алдагдалтай байсан нь нүднээ ил байна. Өнгөц харвал энд, Монгол улс ямагт бага хэмжээтэй гаргаж ихээр оруулж ирсэн байсан мэт. Гэвч хэрэг дээрээ, үүний цаана үнийн маш их зөрүү байжээ.

¹⁰ Мөн тэнд

Монгол, Зөвлөлтийн хоорондын гадаад худалдааны өөрчлөлт
(сая рублиэр)

Он	Нийт бараа эргэлт	Экспорт	Импорт	Үлдэгдэл
1951-1955	677,4	239,2	438,2	-199,0
1956-1960	589,4	231,7	357,7	-126,0
1961-1965	800,9	260,6	540,3	-279,7
1966-1970	743,2	258,3	484,9	-226,6
1971-1975	1539,2	477,1	1062,1	-585,0
1976-1980	3689,3	797,4	2891,9	-2094,5
1981-1985	6555,9	1961,5	4864,4	-3172,9

Эх сурвалж: Д.Сүрэнжав, Манай худалдааны тэнцэл, Эдийн засгийн асуудал № 1, 1990.

Монгол улс экспортын түүхий эдээ дэлхийн зах зээл дээрхи аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээс ямагт доогуур үнээр гаргаж байв. Тийм байдлаар аж үйлдвэрийн бүх төрлийн бүтээгдэхүүнийг импортлодог учраас байнга алдагдалтай наймаа хийж байсан нь түүхэн үнэн юм. Тухайн үед ЭЗХТЗ-д сууж байсан Монголын төлөөлөгчийн орлогч М.Пэлжээ нэг удаа ТАСС-ын сурвалжлагчтай ярилцахдаа: “Монгол улс ямааныхаа ноолуурын тонн тутмыг ЗХУ-д 17 мянган рублиэр гаргаж байна. Гэтэл Унгарт 36 мянган рубль, Японд 85 мянган доллараар гаргадаг. Англи улс 90 мянган доллараар авахад бэлэн байна. Монгол улс жил тутам 1200 тн ноолуур бэлтгэдэг бөгөөд энэ талаар дэлхийд гуравдагч нь юм. Үүнээс жил тутам 300 тн-ыг ЗХУ-д гаргадаг. Хэрвээ бид, бүх ноолуураа тонн тутмыг нь ядаж 50-60 мянган доллараар борлуулдаг бол хүн ардынхаа өргөн хэрэглээний барааг хангалттай хэмжээгээр худалдан авах бололцоо гарахсан билээ” гэсэн байна¹¹.

Монгол, Зөвлөлтийн худалдааны үнийн тухай асуудлыг Монголын тал зөвлөлтийн байгууллагууд төдийгүй төрийн дээд түвшинд ч нэг бус удаа тавьж байжээ. Энэ нь дипломат шугамаар болон ажил хэргийн уулзалт ярианы явцад ч хөндөгдөж байв. Тухайлбал, Ю.Цэдэнбал 1970 оны 10-р сард хоёр орны нам, засгийн төлөөлөгчдийн хэлэлцээрийн үед А.Н.Косылгинд ярьжээ. Тэрээр, мал аж ахуйн бүтээгдэхүүн бол Монголын экспортын гол зүйл болохыг тэмдэглээд: “Манай орны одоогийн 20 сая мал сүргийг 50%-иар өсгөхөд 30 сая болно, гэтэл экспортын хэмжээ дөнгөж 14-15 сая рублиэр өсөх

¹¹ История Монголии. XX век. М. 2007. с.241

юм. Манай экспорт одоо 70 сая рубль байхад, импорт 120 сая байна. Зөрүү маш их байна”¹¹ гэжээ.

1978 оны 8-р сарын 23-нд Ю.Цэдэнбал Крымд Л.И.Брежневтэй ярилцахдаа уг асуудлыг бас хөндсөн. Тэрээр, Буриадын жишээгээр, Монгол, Зөвлөлтийн худалдааны үнийг харьцуулан: “Монголоос мал аж ахуйн бүтээгдэхүүн худалдан авах үнэ ЗХУ-ын дотоод дахь үнээс 3 дахин бага байна. Иймээс мал аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийг өсгөх явдал бидний хамгийн чухал зорилт болсоор байна”¹³ гэж тэмдэглэсэн байдаг.

Ийнхүү ЗХУ бол Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүний үндсэн импортлогч бөгөөд түүнийг үлэмж бага үнээр худалдан авдаг байв. Монгол улсын хувьд өөрөө санхүүгийн чадамж султай учраас мал аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийг нэмэх, малчдын хөдөлмөрийг урамшуулах боломж нь туйлын хязгаарлагдмал байв.

Хоёр орны хоорондын худалдаан дахь үнийн түвшний тухайд Монголын талаас янз бүрийн түвшинд асуудлыг шургуу тавьж хөөцөлдсөн боловч эцсийн дүнд бодитой өөрчлөлт гараагүй билээ. Харин зарим үед мал аж ахуйн зарим бүтээгдэхүүнд “урамшууллын үнэ” нэртэй заримдаг, түр зогоох шинжтэй арга хэмжээ авч байсан нь асуудлын хурцадмал байдал огтхон ч намжаагүй юм.

Монгол, Оросын (ЗХУ) худалдаан дахь ийм тэнцвэргүй байдал л Монгол улс, Зөвлөлт улсад 10 гаруй тэрбум шилжих рублийн өртэй үлдэх явдлын гол үндэс болсон төдийгүй, хоёр орны харилцаанд удтал “цухалдал” тарьж байсан нь нууц бишээ.

Монгол, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд үр ашигтай шинэ арга хэлбэр хэрэгтэй байв. Тухайлбал, хоёр орны аж ахуйн яамд, үйлдвэрийн газар, нэгдлүүдийн хоорондын шууд харилцааг хөгжүүлэх явдал хэрэгтэй байв. Харамсалтай нь бүх эрх мэдэл, төрийн хатуу гарт атгаатай байдаг хуучин үед тийм боломж дэндүү хязгаарлагдмал байсан юм.

Бүхэлд нь авч үзвэл, ЗХУ-аас Монголд үзүүлсэн эдийн засгийн өргөн их тусламж, тус орны нүүр царайг өөрчилсөн нь яах аргагүй үнэн. Өөр нэг тэмдэглэх зүйл бол: ЗХУ Монголд их хэмжээний зээл олгож, түүнийг ашиглахтай холбогдуулан өөрийн мэргэжилтний хэсгүүдийг томилдог байсан. Тийм практик тодорхой үед, нааштай үүрэг гүйцэтгэсэн нь мэдээж боловч бас, сөрөг үр дагавар үүсгэсэн юм. Бүхнийг зөвлөлтийн мэргэжилтний заавар, удирдамжийн дор гүйцэтгэх нь үндэсний боловсон хүчний идэвх санаачлагыг боогдуулж, эцсийн дүнд тэжээвэр сэтгэлгээ Монголын нийгэмд ноёрхоход хүргэсэн юм. Энэ явдал монголчуудад тийм ч таатай байгаагүй билээ.

¹¹ Мөн тэнд

¹³ Мөн тэнд

Бүхэлд нь үзвэл, Монгол, Зөвлөлтийн эдийн засгийн хамтын эерэг бус талууд доорхи байдалтай байсан. Энэ нь:

- Монгол улсын эдийн засгийн бодит хэрэгцээ, боломжийг тусгасан, шинжлэх ухаанд үндэслэсэн хөтөлбөргүйгээр ЗХУ-ын сонирхолд уяж өгсөн;

- ЗХУ-ын техникийн хамтын ажиллагаагаар Монголд байгуулсан үйлдвэрийн газрууд Монголын боломжтой холбогдуулан техник, технологийн өндөр бус түвшинд үндэслэсэн бөгөөд үйлдвэрлэлийн зохион байгуулалт, удирдлагын хувьд тэргүүний арга барилаас хол; УБУ (ГОК) “Эрдэнэ” мэт сайхан үйлдвэрийн газрууд сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй, үндсэндээ үр ашиггүй байв.

- Зөвлөлтийн тал заримдаа зураг төсвийн болон барьж байгуулах ажилд бүдүүлэг алдаа гаргадаг байсан бөгөөд энэ нь: уг үйлдвэрүүдэд шаардлагатай түүхий эд нийлүүлэх боломжоос хэтэрсэн буруу тооцоогоор том объектууд барьж байгуулах; зураг төслийн бичиг баримт цаг хугацаандаа бэлэн болохгүй (тэдгээрийг бэлтгэх нь их төлөв 70%-иас хэтрэхгүй) байх явдал гарч байв¹⁴.

Хамтын үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүний дотоодын бөөний үнийг гадаад худалдааны гэрээний үнэтэй уялдуулах асуудал хэдэн жилээр ч шийдэгдэхгүй үргэлжилж ажил маш их хүндэрч байв. Эдгээр идэвхгүй байдал Монголын талд ямар их хохирол учруулж байсан нь ойлгомжтой. Гэвч хамтарсан үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх арга механизмын өөр сонголт гарахгүй байв. 1990 он хүртэл Монголын гадаад худалдааны гол түнш нь ЗХУ хэвээр байв. Монгол улсын гадаад бодлогын үндсэн чиг хандлага ч урьдын шинж төлөвлөгөө хадгалсаар байсан билээ.

4. Шинэ цагийн гараанд

ЗХУ задран унасан нь Оросын эдийн засгийн хүчийг үлэмж сулруулсан тодийгүй, олон улсын эдийн засгийн харилцааны зарчмын дагуу эдийн засгийн гадаад харилцааны механизмыг ч шинэчлэхэд хүргэсэн нь манай хоёр орны аж ахуйн амьдралд гарцаагүй нөлөөлсөн юм.

Монголын гадаад худалдааны нийт эргэлтэд Оросын эзлэх хувийн жин үлэмж буурав. Энэ нь, нэг талаас, хамтын ажиллагааны хэмжээ хумигдсан, нөгөө талаас, бусад улс орнуудтай монголын харилцаа өргөжсөн явдалтай холбоотой юм.

Шинэ Оросын хувьд ч анхандаа Монголын талаар анхаарал суларсан. Учир нь, хоёр орон хоёулаа эдийн засгийн хувьд хямралт байдалтай болсон.

¹⁴ История Монголии. XX век. М. 2007. с

Үүний дотор Оросын Холбооны Улс гадаад бодлогын талаар өрнөд рүү чиглэх болсон. Монгол улс ч өөрийн олон улсын байр суурийг тэлэх, өмнөх үеийн худалдаа, эдийн засгийн хүчирхэг түншийнхээ байр суурийн багассан зайг нөхөх зайлшгүй шаардлага бий болсон билээ.

1980-аад оны эцэс 1990-ээд оны эхээр Монгол улс, ЗХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаанд уналт мэдэгдэж эхэлсэн. Бэрхшээл ч үүссэн. Үүнд аль аль тал дахь улс төрийн шинэ нөхцөл байдлууд нөлөөлж байв. Гэхдээ энэ талаарх хоёр талын хүчин зүтгэл, хамтын ажиллагааг хэвийн байдлаар сэргээх явдал улс төрийн хувьд эдийн засгийнхаас түрүүлсэн бөгөөд шинэ зам гаргаж чадав.

1991 оны хоёрдугаар сарын 12-нд Монгол улс, Оросын Холбооны Улсын хооронд найрамдал, хамтын ажиллагааны тухай тунхаглалд гарын үсэг зурсан билээ. Тунхаглалын үзэл санааны дагуу хоёр орны харилцаа прагматизм, харилцан ашигтай байх зарчимд тууштай үндэслэх болов. Хоёр тал, олон улсын харилцааны шинэ нөхцөлд харилцаагаа бүх талаар өргөтгөн хөгжүүлэх, хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг эрж олох, эдийн засгийн нээлттэй бодлого явуулах, худалдаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, техникийн зэрэг бүхий л салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн юм. Энэ баримт бичиг Монгол, Оросын бүх талын хамтын ажиллагаа, түүний дотор эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ түүхийн эхлэлийг тавьж өгсөн билээ.

Улаанбаатар, Москвад гарын үсэг зурсан тунхаглал нь өнгөрсөн зууны 90-ээд оны эхээр Монгол Оросын харилцаанд үүссэн бүхий л хүнд байдлыг даван туулахад маш чухал ач холбогдолтой болов. Талууд, 1921 оноос хойших бүх гэрээ, хэлэлцээрүүдэд хамтарсан хяналт, засварлалт хийх шийдвэр гаргаж, аль аль талд гарсан өөрчлөлтүүдтэй холбогдуулан хийх зохицуулалтыг тохиролцсон байна. 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Монгол, Орос хоёр худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсын үнийн дагуу чөлөөтэй хөрвөх валютаар харилцан тооцоо хийхэд үе шаттайгаар шилжих болсон юм. Дурьдсан Тунхаглалтай нэгэн зэрэг 1991 онд, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав. Үүний ач холбогдол нь бараа нийлүүлэх шинэ зарчим буюу индикатив жагсаалтыг үндэс болгох, урьд нь ЗХУ-аас Монголд олгосон зээлийн өрийг арилгах, хамтын үйлдвэрийн газруудад Монголын оруулсан хувь нэмрийг тооцох нөхцлүүдийг тохиролцсонд оршино¹⁵.

Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны эрх зүй, зохион байгуулалтын шинэчлэл нь бас, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комисс (ЗГХК) байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт Москвад

¹⁵ История Монголии. XX век. М.2007.с.377

1991 онд гарын үсэг зурснаар баталгаажсан юм. Энэ комиссын хурал 1992 онд Улаанбаатарт болсноос хойш эдүгээ 10 гаруй удаа хуралдаад байгаа юм. Түүнчлэн 1992 онд харилцан хийх төлбөрийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсан.

Монгол, Орос хоёрт эхэлсэн өөрчлөн байгуулалт болон нийгэм, эдийн засгийн хямрал хамтарсан үйлдвэрийн газрын ашигт ажиллагаанд ч тийм сайнаар тусаагүй юм. Газар ба түүний хэвлийн ашиглалтын төлбөрийн тухай, бүтээгдэхүүн хуваах журмын тухай болон бусад асуудлууд босч ирэв. Тэдгээрийг шийдвэрлэх оролдлого хэдий тал хагас ч гэсэн Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах (УБҮ) “Эрдэнэт”-ийн үйл ажиллагааны тухай 1991 оны 6 дугаар сарын 5-ны протоколд туссан байна. Улмаар үйлдвэрийг газрыг удирдахад талууд хэрхэн оролцох тухай янз бүрийн байр суурьтай холбогдсон асуудлууд гарч ирэв. Үүний улмаас 2003 оны “Эрдэнэт”-ийг Монгол-Оросын хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болгож өөрчлөн зохион байгуулав.

Орос-Монголын хувь нийлүүлсэн нийгэмлэг-Улаанбаатар төмөр замын ачаа тээвэрлэлт огцом унаж, байдал бас хүндрэв. Гэвч богино хугацаанд хүнд байдлыг үндсэнд нь давав. Үүний зэрэгцээ, хамтын бас нэг том үйлдвэр “Монголросцветмет”-ийг шинэчлэх гэсэн өөр нэг чухал асуудал гарч ирснийг хоёр тал авч үзэв. Ийм нөхцөл байдлын дунд Монгол, Орос хоёр улсын эдийн засгийн шинэ харилцааны үндэс тавигдав. Өмнө дурьдсан Тунхаглал болон бусад баримт бичгүүдийн агуулга тэр дороо л хэрэгжиж эхэлсэнгүй, наад зах нь 1 жил хагасаас 2 жил хүртэл сунжирч байв. Худалдаа, эдийн засгийн харилцаанд тодорхой “амсхийлт” гарсан. 1993 оны 1 дүгээр сарын 23-нд Монгол улс, Оросын Холбооны Улсын хооронд найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ байгуулагдсанаас хойш нөхцөл байдалд нааштай өөрчлөлт мэдэгдэхүйц болж ирсэн юм.

Монголд түлш, эрчим хүчний цогцолбор болон тээвэр, аялал жуулчлал, барилга, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдаа хөгжүүлэх асуудлаар Засгийн газар хоорондын комиссын боловсруулсан меморандумд тодорхой үндэслэлүүдийг боловсруулан тавив.

Монгол, Оросын худалдаа-эдийн засгийн харилцаа 1990-ээд оныхтой харьцуулахад шинэ зууны эхээр мэдэгдэхүйц өсөв. Зөвхөн 2001 онд хоёр орны хоорондын бараа эргэлт 25%-иар өссөн байна. Түүнчлэн хил орчмын худалдаа аажмаар өргөжиж байна. Оросын хувьд Сибирийн бүс нутаг Монголтой хийх худалдааны харилцаанд илүү өргөн оролцох боллоо.

2000 оны байдлаар тэр нь хоёр орны хоорондын таваарын нийт эргэлтэд 70% эзэлж байв. Хамтын ажиллагааны стратегийн үндсэн чиглэл бол Монголд

уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх, Сибирээс эрчим хүч экспортлох, Монголоос Орост мах нийлүүлэх явдал болно.

Шинэ зууны босгон дээрх Монгол, Оросын эдийн засгийн харилцааны шийдвэрлэгдсэн нэг том асуудал бол Монголчуудын хэлдгээр “Их өр”-ийн асуудал. Хуучин ЗХУ-ын халаа болохын хувьд шинэ Оросын удирдлага асуудалд шинэ байдлаар хандаж хоёр тал удтал хэлэлцсэний дүнд, харилцааны шинэ зарчмуудыг үндэс болгон 2003 онд нийт өр /хүүгийн хамт 11 тэрбум шилжих рубль/-ийн 98%-ийг чөлөөлсөн билээ. Монгол улс ердөө 250 сая доллар төлснөөр өр бүрэн хаагдсан юм. Тэр үеийн Монгол улсын Ерөнхийлөгчид Оросын Ерөнхийлөгчөөс ирүүлсэн илгээлтэд өгүүлснээр, Энэ асуудлыг шийдсэн нь хөрөнгө оруулалтын хүрээг хамруулан манай орнуудын харилцааг цаашид иж бүрнээр хөгжүүлэх өргөн бололцоог нээж өгсөн юм¹⁶.

¹⁶ История Монголии. XX век. М.2007. с.385